



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР

www.sportarbitration.mn



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ



Н.ЦОГТСАЙХАН

Давж заалдах комиссын гишүүн



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



АГУУЛГА

1. ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГЫН ОЛОН УЛСЫН
СТАНДАРТ ГЭЖ ЮУ ВЭ?

2. ҮНДСЭН БҮЛГҮҮД

3. ДҮГНЭЛТ






МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



НЭГ. ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГА ГЭЖ ЮУ ВЭ?



Зөрчигдсөн допингийн эсрэг
дүрмийн хэргийг хянан
шийдвэрлэх ажиллагаа



ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

- Дэлхийн Допингийн эсрэг дүрмийн хавсралт, заавал мөрдөх олон улсын стандартын нэг
- 11 бүлэг, 3 хавсралттай
- Шинжилгээний хариу хүлээн авахаас эхлэн давж заалдах хүртлэх бүх үе шатыг багтаасан
- Допингийн эсрэг байгууллагуудын үр дүнгийн удирдлагын ажиллагаатай холбоотой үндсэн үүргийг тодорхойлоход оршино.





ҮР ДҮНГИЙН УДИРДЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

- 1 дүгээр бүлэг: Танилцуулга
- 2 дугаар бүлэг: Дүрмийн заалт
- 3 дугаар бүлэг: Тодорхойлолт ба тайлбар
- 4 дүгээр бүлэг: Ерөнхий зарчим
- 5 дугаар бүлэг: Шүүхийн шийдвэрийн өмнөх байдал
- 6 дугаар бүлэг: Түр түтгэлзүүлэлт
- 7 дугаар бүлэг: Хариуцлага
- 8 дугаар бүлэг: Хэрэг хянан шийдвэрлэх
- 9 дүгээр бүлэг: Шийдвэр
- 10 дугаар бүлэг: Давж заалдах
- 11 дүгээр бүлэг: Эрх хасуулсан хугацаанд тэмцээнд оролцохыг хориглосон заалтын зөрчил



ЕРӨНХИЙ ЗАРЧИМ





Үндэсний түвшинд Үр дүнгийн удирдлага хариуцах



**Үндэсний допингийн
эсрэг байгууллага**



Шинжилгээний хариуг хүлээн
авахаас



Хэрэг хянан шийдвэрлэх
ажиллагаа хүртэл



**хэрэг хянан шийдвэрлэх
комисс**



Хэрэг хянан шийдвэрлэх
ажиллагаа явуулах



Давж заалдах комисс



Давж заалдах
шатны ажиллагаа



Шаардлагатай бол анхан
шатны хэрэг хянан
шийдвэрлэх ажиллагаа



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



ХОЁР. ҮНДСЭН БҮЛГҮҮД





Ерөнхий зарчим 4 дүгээр бүлэг



4.1 Үр дүнгийн удирдлагын нууцлал

Олон нийтэд мэдээлэх, үр дүнгийн удирдлагатай холбоотой бүхий л үйл явц, үйл ажиллагаа зэрэг дүрмийн 14 дүгээр бүлэг, эсвэл энэхүү стандартын дагуу шаардсан, эсвэл зөвшөөрөгдсөн мэдээллийн нууцлалыг хадгална.



4.2 Цаг хугацаа

Спортын шударга, үр дүнтэй байдал, шударга ёсыг хангах зорилгоор допингийн эсрэг дүрмийн зөрчлийг цаг тухайд нь шүүх шаардлагатай. Допингийн эсрэг дүрмийн зөрчлийн төрлөөс үл хамааран нарийн төвөгтэй асуудал, допингийн эсрэг байгууллагын хяналтанд ороогүй саатал (жишээ нь тамирчин болон бусад этгээдэд хамааралтай саатал) гарахаас сэргийлэн допингийн эсрэг байгууллагууд энэ дүрмийн 5 дугаар бүлэгт заасны дагуу мэдэгдэл хийснээс хойш зургаан (6) сарын дотор үр дүнгийн удирдлагыг (анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх үйл явцыг багтаасан) ажиллагааг явуулах боломжтой байх шаардлагатай.



Эхний хянан үзлэг /5.1.1/



5.1.1.1 Эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл шалгах / байгаа эсэх, уг зөвшөөрөл нь ЭЗЧ стандартын /4.2/ дагуу олгогдсон эсэх/

5.1.1.2 “Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандарт”, эсвэл “Лабораторийн” олон улсын стандартаас гажсан эсэх


5.1.1.3 Хориглосон бодисыг зөвшөөрөгдсөн замаар хэрэглэсэн эсэх /хориглосон жагсаалт, допингийн хяналтын хуудас/



Эхний хянан үзлэг /5.1.1/





“Шинжилгээ, мөрдөн шалгалтын олон улсын стандарт”,
“Лабораторийн” олон улсын стандартаас гажсан эсэх




• Тамирчинд мэдэгдэнэ.
ISRM: 5.1.2



Эмчилгээний зорилгоор
чөлөөлөх зөвшөөрөл
байгаа эсэх



Хориглосон бодисыг
зөвшөөрөгдсөн замаар
хэрэглэсэн эсэх



• Допингийн эсрэг дүрмийн зөрчил гэж үзэхгүй
• Үр дүнгийн удирдлагын ажиллагааг үргэлжлүүлэхгүй



Мэдэгдэл /5.1.2.1/

Хянан үзлэгээр сөрөг аналитик илэрц нь “Эмчилгээний зорилгоор чөлөөлөх” олон улсын стандартад заасны дагуу олгогдсон эмчилгээний зорилгоор чөлөөлөх зөвшөөрөл байхгүй болон “Шинжилгээ, мөрдөн шалгалтын” олон улсын стандарт, эсвэл “Лабораторийн” олон улсын стандартын илэрхий гажилттай холбоогүй, эсвэл уг сөрөг аналитик илэрц нь зөвшөөрөгдсөн замаар биед орсон хориглосон бодисоос шалтгаалсан дараахи зүйлийг тамирчинд нэн даруй мэдэгдэнэ



Мэдэгдэл /5.1.2/

А. Сөрөг аналитик илэрц гарсан тухай/

Б. Сөрөг аналитик илэрц нь дүрмийн 2.1, 2.2 заалттай холбоотой байх тухай/

В. Тамирчин эрхийнхээ дагуу "Б" сорьцыг шинжлүүлэх хүсэлт гаргаж болох, эсвэл хүсэлт гаргаагүй тохиолдолд "Б" сорьц шинжлүүлэхээс татгалзсан гэж үзэх тухай;

Г. Тамирчин, эсвэл тамирчны төлөөлөгч “Лабораторийн” олон улсын стандартын дагуу "Б" сорьцыг задлах, шинжлэх ажиллагаанд оролцох боломжтой тухай;





Мэдэгдэл /5.1.2/

Д. Тамирчин “Лабораторийн” олон улсын стандартын шаардлагын дагуу мэдээллийг багтаасан "А" сорьцын бичиг баримтын багцын хуулбарыг хүсэх эрхтэй тухай;

Е. Богино хугацаанд тайлбар өгөх боломжоор тамирчныг хангах тухай;

Ж. Тамирчин дүрмийн 10.7.1 заасны дагуу бодит туслалцаа үзүүлэх эсвэл 10.8.1 т заасан шийтгэлийг 1 жилээр бууруулах боломж олгох тухай

З. Түр түтгэлзүүлэлт оноох тухай;



Түр түтгэлзүүлэлт 6 дугаар бүлэг



- 6.1.1 Зарчмын хувьд түр түтгэлзүүлэлт гэж энэхүү стандартын 8 дугаар бүлэгт заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шийдвэр гарах хүртэл хугацаанд дүрмийн 10.14.1 зүйлийг баримтлан тамирчин, эсвэл бусад этгээдийн аливаа тэмцээн, уралдаанд оролцох эрхийг түр хориглох үйлдлийг ойлгоно.
- Түр түтгэлзүүлэлтийн хугацаанд тамирчны оролцсон тэмцээний бүх үр дүнг автоматаар хүчингүй болгоно.



Түр түтгэлзүүлэлт 6 дугаар бүлэг

А. Албан журмын



Дэлхийн Допингийн эсрэг дүрмийн 7.2 заалтыг баримтлан мэдэгдэл өгөх үед нэн даруй онооно.

Б. Албан журмын бус

Дэлхийн Допингийн эсрэг дүрмийн 7.4.1 т зааснаас бусад тохиолдолд нотлох баримтыг үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эцсийн шийдвэр гарахаас өмнө

В. Сайн дурын түр түтгэлзүүлэлт



ХАРИУЦЛАГА 7 дугаар бүлэг /2 дах удаагийн мэдэгдэл/



7.1 Үр дүнгийн удирдлагын ажиллагааны эрх бүхий байгууллага нь тамирчин, эсвэл бусад этгээдийн тайлбарыг хүлээн авсны дараа, эсвэл тайлбар өгөх тогтоосон хугацаа дууссаны дараа тамирчин, эсвэл бусад этгээд допингийн эсрэг дүрмийг зөрчсөн гэдэгт итгэлтэй болсон бол тамирчин, эсвэл бусад этгээдэд допингийн эсрэг дүрмийг зөрчсөн гэж үзэж буй тухай нэн даруй мэдэгдэнэ.



ХАРИУЦЛАГА 7 дугаар бүлэг

МЭДЭГДЛИЙН АГУУЛГА:

А. Тамирчин, эсвэл бусад этгээдийн зөрчсөн гэж үзсэн допингийн эсрэг дүрмийн заалтыг тусгана,

Б. Өмнөх мэдэгдэлд тусгагдаагүй шинээр илэрсэн нөхцөл байдал, нотлох баримтын талаар

В. Допингийн эсрэг дүрмийн зөрчил илэрсэн тохиолдолд оноож болох үр дагаварын талаарх мэдээлэл

Г. Допингийн эсрэг дүрмийн зөрчилд оноох үр дагаварыг сайн дураар хүлээн зөвшөөрөх боломжтой тухай





ХАРИУЦЛАГА 7 дугаар бүлэг

МЭДЭГДЛИЙН АГУУЛГА:

Д.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийлгэлгүй үр дагаварыг шууд хүлээн зөвшөөрөх боломжтой тухай

Е. Үр дагаварыг шууд хүлээн зөвшөөрөхгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийлгэх хүсэлт гаргах боломжтой тухай . Дурдсан хугацаанд хүсэлт гаргаагүй бол хүлээн зөвшөөрсөнд тооцно.

Ё. Тамирчин дүрмийн 10.7.1 заасны дагуу бодит туслалцаа үзүүлэх эсвэл 10.8.1 т заасан шийтгэлийг 1 жилээр бууруулах боломж олгох тухай





ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ISRM: 8 дугаар бүлэг

Бүрэлдэхүүн:

8.2 Хэрэг хянан шийдвэрлэх комиссыг гишүүдийн хууль, спорт, анагаах ухаан, шинжлэх ухааны мэдлэг зэрэг допингийн эсрэг үйл ажиллагааны туршлагад суурилан байгуулна. Хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний бүх гишүүдийг хоёроос (2) доошгүй жилийн хугацаагаар томилно.(дахин сонгогдох боломжтой).

8.3 Холбогдох дүрмээр хараат бус этгээд, эсвэл хуулийн этгээдийг тухайн хэргийн цар хүрээ, бүтцээс хамааран хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжоор хангана. Тухайн хэргийг хянан шийдвэрлэхээр томилогдсон хамгийн багадаа нэг гишүүн нь хууль, эрх зүйн боловсролтой байх шаардлагатай.





ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ISRM: 8 дугаар бүлэг

Зарчим 8.8



А. Хэрэг хянан шийдвэрлэх комисс нь бүх цаг үеийн туршид шударга, ялгаварлалгүй, үйл ажиллагааны хувьд хараат бус байх шаардлагатай;

Б. Хэрэг хянан шийдвэрлэх үйл явц нь хүртээмжтэй, хямд байх

В. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боломжит цаг хугацаанд явуулна;



ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ISRM: 8 дугаар бүлэг

Зарчим 8.8



Г. Допингийн эсрэг дүрмийн зөрчил гаргасан тухай шударгаар, цаг тухайд нь мэдээлэх эрх, тамирчин болон бусад этгээд өөрийн зардлаар өмгөөлөгч авах эрх, нотлох баримтыг бичгээр болон амаар өгөх эрх, гэрчийг дуудах, мэдүүлэг авах эрх, тамирчин болон бусад этгээд өөрийн зардлаар хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанд хэлмэрч оролцуулах эрхийг хангах



ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ISRM: 8 дугаар бүлэг

Зарчим 8.8



Д. Тамирчин, эсвэл бусад этгээд хэрэг хянан шийдвэрлэх хуралдааныг олон нийтийн өмнө нээлттэй хийлгэх хүсэлт гаргах эрхтэй. Үр дүнгийн удирдлагын ажиллагааны эрх бүхий байгууллага нь тамирчин, эсвэл бусад этгээд бичгээр зөвшөөрөл өгсөн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх хуралдааныг олон нийтийн өмнө нээлттэй хийлгэх хүсэлт гаргаж болно.



ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ISRM: 8 дугаар бүлэг

Зарчим 8.8

Д. Тайлбар:



Гэсэн хэдий ч олон нийтэд нээлттэй хийх нь шударга ёсны ашиг сонирхлыг хохироох, эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн хуулийн асуудалтай холбоотой бол насанд хүрээгүй этгээдийн ашиг сонирхол, эсвэл талуудын хувийн амьдралыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд ёс суртахуун, нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болно.



ШИЙДВЭР ISRM: 9 дүгээр бүлэг

Агуулга

А. Хууль зүйн үндэслэл ба холбогдох дүрмүүд;

Б. Баримтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

Жишээлбэл, зөрчил нь сөрөг аналитик илэрцэд үндэслэгдсэн бол шийдвэрт дээж цуглуулсан огноо, газар, цуглуулсан дээжийн төрөл (цус, шээс), допингийн хяналт нь тэмцээний эсвэл тэмцээний бус үеийнх байсан эсэх, илэрсэн хориглосон бодис, шинжилгээ хийсэн ДДЭА магадлан итгэмжлэгдсэн лаборатори, хэрэв “Б” сорьцын шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан эсэх, “Б” дээжийг шинжлүүлсэн бол түүний хариу зэргийг тусгана. Бусад аливаа зөрчлийн хувьд баримтын бүрэн, дэлгэрэнгүй тайлбарыг багтаана.





ШИЙДВЭР ISRM: 9 дүгээр бүлэг

Агуулга

В. Зөрчигдсөн допингийн эсрэг дүрэм;

Зөрчил нь сөрөг аналитик илэрцэд үндэслэсэн бол, шийдвэрт бусад олон улсын стандартаас гажсаагүй, эсвэл гажих сэжиг илрээгүй, энэ нь сөрөг аналитик илэрц гарах шалтгаан болоогүй болон гарсан зөрчил нь дүрмийн 2 дугаар бүлгийг зөрчсөн болохыг тусгана. (Дүрмийн 2.1.2 зүйлийг үзнэ үү). Бусад зөрчлийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн нь ирүүлсэн нотлох баримтыг үнэлж, үр дүнгийн удирдлагын ажиллагааны эрх бүхий байгууллагаас ирүүлсэн нотлох баримт нь нотлох баримтын стандартад нийцсэн, эс нийцсэн гэж үзсэн тухай тайлбарлана. .





ШИЙДВЭР ISRM: 9 дүгээр бүлэг

Агуулга

Г.Холбогдох үр дагавар



- *Шийдвэрт аливаа хөнгөлөлт, түтгэлзүүлэлт, холбогдох үр дагаврыг оноох үндэслэл зэрэг тухайн шийтгэлтэй холбоотой онцгой заалтууд*
- *Эрх хасах хугацааг тооцож эхлэх, түүний үндэслэлийн тухай*
- *Амжилтыг хүчингүй болгох, эсвэл хүчингүй болгохгүй байх үндэслэл*
- *Түр түтгэлзүүлсэн хугацааг эрх хасах хугацаанд оруулж тооцох эсэх*
- *Санхүүгийн үр дагавар оноох*



ШИЙДВЭР ISRM: 9 дүгээр бүлэг

Агуулга



Д. Давж заалдах боломжийн талаар

- *Давж заалдах өргөдөл гаргах эцсийн хугацаа*
- *Давж заалдах өргөдөл гаргах газрын нэр, хаяг*



ШИЙДВЭРИЙГ МЭДЭГДЭХ ISRM: 9.2

Үр дүнгийн удирдлага хариуцсан байгууллага нь дараах зүйлийг мэдэгдэнэ.



А. Дүрмийн 10.14 т заасан эрх хасуулах үеийн төлөв байдлын талаар

Б. Эрх хасуулсан хугацаандаа шинжилгээнд хамрагдах үүрэгтэй болох тухай

В. Давж заалдах эрх бүхий байгууллага шаардсан тохиолдолд шийдвэрээс гадна тухайн хэргийн хуулбарыг гаргаж өгнө.

Г. Давж заалдах хугацаа өнгөрсөн эсвэл, давж заалдах өргөдөл гаргаагүй бол хэрэг эцэслэн тухай лабораторид мэдэгдэнэ.



ДАВЖ ЗААЛДАХ 10 дугаар бүлэг



Дүрмийн 13 дугаар бүлэгт зааснаар зохицуулна.

Давж заалдах гомдол гаргах болон хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг спортын арбитрын дүрмээр зохицуулна.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР




ГУРАВ. ДҮГНЭЛТ





МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР



CAS-т гомдол гаргах

Шийдвэр хүчинтэй

www.sportarbitration.mn



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР

